

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.05.28



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.93%
Монгол 27	2027.07.07	3.50%	6.92%
Хүннү	2028.01.19	8.65%	6.75%
Монгол 29	2029.06.05	7.875%	7.14%
Монгол 30	2030.02.25	6.625%	7.18%
Монгол 31	2031.07.07	4.45%	7.21%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.93%-7.21% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	10.48%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.75%
TDBM	2027.12.23	8.5%	10.48%
DBM	2026.03.07	11.00%	8.35%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 8.35%-10.48%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

ГС Бондын супермаркет нь хөрөнгө оруулагчдадаа бэлэн бондын тасагт байгаа 5 сарын хамгийн эрэлттэй бондуудаа санал болгож байна.

Дэд бүтэц : \$10%
Банк санхүү : ₮20%
Ул хөдлөх : ₮18%-20%
Уул уурхай : \$11%



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

Бондын хямрал биткойны үнийг өсгөж байна.

Дэлхийн бондын зах зээл хямарч, АНУ болон Японы урт хугацаат бондын өгөөж огцом өсөж ханш нь унаж байна. Тиймээс хөрөнгө оруулагчид уламжлалт аюулгүй хөрөнгөөс зугтаж, Bitcoin руу хандаж эхэллээ. Мөн АНУ-ын 30 жилийн бондын өгөөж 5.15%-д хүрч, 36.8 их наяд долларын өрийн хүүгийн дарамт улам нэмэгдэж байна.

Төв банк бодлогын хүүг бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэх алхам хийхээс зайлсхийж байгаа нь зах зээлд итгэл сулруулах шалтгаан болж байна.

Японд ч мөн ижил нөхцөл үүсэж, бондын өгөөж 1999 оноос хойших дээд түвшинд хүрч, ерөнхий сайд өрийн байдал Грекийнхээс дор байгааг хүлээн зөвшөөрсөн.

Ийм нөхцөлд Bitcoin улам эрэлттэй болж, институциональ хөрөнгө оруулагчид уламжлалт хувьцаа, бондоос илүүтэй Bitcoin-ийг аюулгүй, улс төрөөс ангид үнэ цэнтэй хөрөнгө гэж үзэх хандлага нэмэгдэж байна.

АНУ-ын бондын ханш огцом савлаж, хөрөнгийн зах зээлд сөрөг дохио илгээв

Өнгөрсөн долоо хоногийн эхэнд харьцангуй тайван байсан хөрөнгийн зах зээл лхагва гарагийн үдээс хойш огцом уналттай тулгарсан. Үүнд голлон нөлөөлсөн үйл явдал бол 20 жилийн хугацаатай Засгийн газрын бондын тааруухан дуудлага худалдаа байв. Энэ нь урт хугацааны бондын өгөөжийг өсгөж, 30 жилийн бондын өгөөж 2023 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн юм.

Хэдий долоо хоногийн төгсгөлд бондын зах зээл хэсэгчлэн сэргэж эхэлсэн ч энэ уналт нь зах зээлд тодорхой хэмжээнд итгэлгүй байдал үүсгэсэн.

Уг хямралыг Moody's агентлаг АНУ-ын зээлийн үнэлгээг бууруулсантай холбон тайлбарлаж байна. Moody's энэ алхмыг АНУ-ын төсвийн алдагдал нэмэгдэж, улсын өр өсөж буйд санаа зовнин хийсэн гэж тайлбарласан.

График 2. АНУ-ын 20 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж





БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

2025 оны 5-р сарын 19- 23 өдрийн хооронд ББ33-д нийт 85,459 ширхэг үнэт цаас 56.2 тэрбум төгрөгөөр, 522 ширхэг үнэт цаас 554 мянган ам.доллараар арилжаалагдсан байна.

Үүнээс анхдагч зах зээлд 41,715 ширхэг үнэт цаас 32,850,000,000 төгрөгөөр, 500 ширхэг үнэт цаас 500,000.0 ам.доллараар арилжаалагджээ. Харин хоёрдогч зах зээлд 43,744 ширхэг үнэт цаас 23,386,442,452 төгрөгөөр, 22 ширхэг үнэт цаас 54,103.96 ам.доллараар арилжаалагдлаа.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ТУСГАЙ САНАЛ 30%

☎ 8083-6622 | 8888-9183 | 8665-4422 | 8083-9944